

## **Тусгай зөвшөөрлийн мэдээлэл**

1. Согтууруулах ундаа импортлох
  - а. 2-25 хүртэл хувийн хатуулагтай согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл /шинээр авах, сунгуулах, сэргээх/
  - б. 25-40 хүртэл хувийн хатуулагтай согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл /шинээр авах, сунгуулах, сэргээх/
  - в. 40 ба түүнээс дээш хувийн хатуулагтай согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл /шинээр авах, сунгуулах, сэргээх/
2. Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл олгоход хатуулгаас нь шалтгаалан доор дурдсан хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамж төлнө.
  - а. 2-25 хүртэл хатуулагтай согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл олгоход 20,000,000 (хорин сая) төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад 10,000,000 (арван сая) төгрөг;
  - б. 25-40 хүртэл хатуулагтай согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл олгоход 100,000,000 (нэг зуун сая) төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад 50,000,000 (тавин сая) төгрөг;
  - в. 40 ба түүнээс дээш хатуулагтай согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл олгоход 150,000,000 (нэг зуун тавин сая) төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад 75,000,000 (далан таван сая) төгрөг;

## **Тусгай зөвшөөрөл шинээр авах болон хугацаа сунгуулахад бүрдүүлэх баримт бичиг**

1. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл (Байгууллагын албан ёсны хаяг, цахим шуудангийн хаяг, эрх бүхий этгээдийн утасны дугаар зөв байх);
2. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт (улсын тэмдэгтийн хураамжийг Банзүрх дүүргийн Татварын хэлтэст цахимаар хандан хүсэлт гарган төлбөрийн даалгаварын дагуу байгууллагын данснаас төлөх);
3. Урьд өмнө үйл ажиллагаа эрхэлж байсан бол аудитын байгууллагаар баталгаажуулсан сүүлийн гурван жилийн санхүүгийн тайлан;
4. Импортлох бүтээгдэхүүнээ хадгалах агуулахын талаарх мэдээлэл ("цагдаагийн байгууллагын санал"-д тусгагдсан агуулахын хаягтай тохирч байх);
5. Импортлох согтууруулах ундаа үйлдвэрлэсэн болон экспортолсон улс орны чанар, стандартын шаардлага хангаж байгааг тодорхойлсон гэрчилгээ, баримт бичиг;
6. Импортлох бүтээгдэхүүн бүрд дахин давтагдашгүй, цахим өгөгдөл бүхий кодтой онцгой албан татварын тэмдэг үйлдэх, үйлдсэн тэмдгийн талаарх мэдээллийг цахим төлбөрийн баримтын системд холбох тоног төхөөрөмж шаардлага хангасан эсэх талаар татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлт;
7. Үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулж, энэ талаар цагдаагийн байгууллагын санал;

8. Импортлох согтууруулах ундааны загвар дээжийг гаалийн байгууллагын урьдчилан шинжилгээнд хамруулж, эрүүл ахуйн шаардлага хангасан талаарх баримт;
9. Импортын согтууруулах ундаа хадгалах барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулсан талаарх цагдаагийн байгууллагын санал;
10. Татварын өргүй талаар татварын байгууллагын тодорхойлолт.

Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахад дээрх нийтлэг шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна.

- a. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний эх хувь
- b. Тусгай зөвшөөрөл шинээр авахад байгуулсан гэрээг дүгнэж, гэрээ дүгнэсэн акт үйлдсэн байх;
- c. Цахим төлбөрийн баримтын систем, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдсон байх;
- d. Онцгой албан татварын тэмдэг бүхий согтууруулах ундаа импортлох;
- e. Борлуулалт хийх бүрд цахим төлбөрийн баримт олгох, импорт, худалдаа бүрийг “Согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бүртгэл болон холбогдох бусад мэдээллийг агуулсан мэдээллийн цахим санг бүрдүүлэх, ашиглах, баяжуулах журам”-ын дагуу бүртгэх.

Тусгай зөвшөөрөл шинээр олгосон тохиолдолд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай гэрээ байгуулна. Гэрээний загварыг энд дарж үзнэ үү.

Бүрдүүлэх бичиг баримтын талаарх мэдээллийг Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ хуулиас эсвэл [энд дарж](#) үзнэ үү

Төлбөрийн талаарх мэдээллийг “Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 173 дугаар тогтоол эсвэл [энд дарж](#) үзнэ үү.